

САНХҮҮГИЙН ХЯНАЛТ ШАЛГАЛТ ХИЙСЭН ДҮНГИЙН ТУХАЙ

НЭГ. ХЯНАЛТ ШАЛГАЛТЫН ЗОРИЛГО

Булган аймгийн Засаг даргын дэргэдэх Санхүүгийн хяналт, аудитын албаны 2019 оны хяналт шалгалтын нэгдсэн төлөвлөгөө Санхүүгийн хяналт, аудитын албаны даргын 2019 оны 05 сарын 31-ны өдрийн 1/08 дугаар удирдамжийн дагуу Булган сумын 2-р цэцэрлэгийн 2017,2018 оны санхүү, аж ахуйн үйл ажиллагаанд Монгол Улсын Төсвийн тухай, Нягтлан бодох бүртгэлийн тухай, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа ажил үйлчилгээ худалдан авах тухай хуулиуд болон тэдгээртэй нийцүүлэн гаргасан бусад эрх зүйн актуудын хэрэгжилтийг шалгаж, зөрчил дутагдал илэрсэн тохиолдолд холбогдох хуулийн дагуу шийдвэрлэх, аливаа эрсдлээс урьдчилан сэргийлэх, цаашид давтан гаргахгүй байх талаар мэргэжил арга зүйн заавар, зөвлөгөө өгөхөд чиглэгдлээ.

ХОЁР. ХЯНАЛТ ШАЛГАЛТЫН БҮРЭЛДЭХҮҮН, ХУГАЦАА

Санхүүгийн хяналт шалгалтын улсын ахлах байцаагч Б.Баттулга, Аудитор П.Пүрэвжав, Б.Нямсүрэн нар 2019 оны 05 сарын 31-ны өдрөөс ажлын 14 өдөр шалгалтыг хийв.

ГУРАВ. ШАЛГАЛТАНД ХАМРАГДСАН АСУУДЛУУД

Цэцэрлэгийн 2017, 2018 оны касс, харилцах дансны гүйлгээг санхүүгийн анхан шатны баримттай тулган шалгасны зэрэгцээ цалин хөлс, урамшуулал, албан томилолтын бодолт, олголт, шатахууны олголт түүний зарцуулалтыг автомашины замын хуудастай тулгаж, бараа материалын худалдан авалт, зарцуулалт, эд хөрөнгийн тооллого тооцоо бодолт, санхүү, төсвийн ил тод байдлын хэрэгжилт, Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт зэрэг хяналт шалгалтын удирдамжид заагдсан асуудлуудыг бүрэн хамруулан нягтлан бодогч Ж.Отгонтуяа нярав Л.Мандах нарыг байлцуулан төлөвлөгөөт хяналт шалгалтыг хийв.

ДӨРӨВ. ШАЛГАЛТАНД ХАМРАГДСАН ОБЪЕКТЫН ТАЛААРХ ТОВЧ МЭДЭЭЛЭЛ

Булган сумын 2-р цэцэрлэг нь 2017-2018 оны хичээлийн жилд хүүхэд нэг бүрийг хөгжүүлэх сургалтын цөм хөтөлбөрийг хэрэгжүүлэх, 2018-ны хичээлийн жилд тус цэцэрлэг нь сургуулийн өмнөх боловсролын сургалтын цөм хөтөлбөрийг хэрэгжүүлэх,

СӨББ-ын орчны стандартыг мөрдөж бага насны хүүхдийг хөгжүүлэх, төлөвшүүлэхэд үйл ажиллагаагаа чиглүүлэн ажилласан байна. Тус цэцэрлэг нь 2017 онд эрхлэгч 1, арга зүйч 1, туслах багш 9, багш 9, тогооч 1, туслах тогооч 2, нягтлан бодогч 1, нярав 1, угаагч 1, үйлчлэгч 1, жижүүр 3 нийт 30 орон тоотойгоор үйл ажиллагааг явуулж төсөвт зардлыг зориулалтын дагуу зарцуулж ажилласан байна.

ТАВ. ӨМНӨХ ШАЛГАЛТЫН ТАЛААРХ МЭДЭЭЛЭЛ

Аудитын дүгнэлтээр Булган сумын 2-р цэцэрлэгийн 2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө, өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээ болон төсвийн гүйцэтгэлийн тайланг материаллаг зүйлсийн хувьд Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, ОУНББОУС-д нийцүүлж Сангийн сайдын баталсан бодлого, журам, зааврын дагуу үнэн, бодитой шударга илэрхийлсэн тул зөрчилгүй санал дүгнэлт гаргасан байна.

Булган аймгийн татварын хэлтэсийн 2019 оны төлөвлөгөөт хяналт шалгалтаар Булган сумын 2-р цэцэрлэгийн 2014.01.01-2018.01.01 дуустал албан татвар ногдуулалт, төлөлтийн талаар 2019 оны 3-р сард хийсэн шалгалтаар шалгалтанд хамрагдсан хугацааны албан татвар ногдуулалт, төлөлтийн байдалд зөрчил илрээгүй тул илтгэх хуудас бичсэн байна.

ЗУРГАА. ШАЛГАЛТЫН ЯВЦАД ХИЙГДСЭН АЖИЛ, ШАЛГАЛТАНД ХАМРАГДСАН АСУУДЛУУД

6.1. Санхүүгийн эх үүсвэрийн бүрдүүлэлт, зарцуулалтын талаар: 2018 онд улсын төсвөөс 463963.9 мянган төгрөг, нэмэлт санхүүжилтээр 1427.1 мянган төгрөг. Үйл ажиллагааны зардал 465886.7 мянган төгрөг, бараа, ажил үйлчилгээний зардал 454023.2 мянган төгрөг,

Цалин урамшууллын талаар: Булган сумын 2-р цэцэрлэгийн эрхлэгчийн 2018 оны 01 сарын 24-ны өдрийн А/02 тоот тушаалаар ур чадварын нэмэгдэлдийг дуу хөгжмийн багш Т.Уранбайгаль, арга зүйч Ч.Оюундэлгэр, багш О.Эрдэнэ-Оюун, туслах багш Д.Нансалмаа, туслах тогооч Ө.Болор-Эрдэнэ нарт 10%-аас 15%-иар буюу 426.7 мянган төгрөг, эрхлэгчийн 2018 оны 01 сарын 29-ны өдрийн А/04 тоот тушаалаар Бүлгийн багш Ч.Оюундэлгэр, Д.Оюун-Эрдэнэ туслах багш Б.Отгончимэг, Д.Нансалмаа нарт 5 жил тутамд нэг удаа 6 сарын үндсэн цалинтай мөнгөн тэтгэмж болох 11152.2 мянган төгрөг, мөн оны 02 сарын 09-ны өдрийн А/05 тоот тушаалаар багш Б.Чанцалдуламд ур чадварын нэмэгдэл 15%-иар буюу 82.5 мянган төгрөг, 02 сарын 09-ний өдрийн А/06 тоот тушаалаар арга зүйч Ч.Оюундэлгэр, жижүүр Б.Нямдорж нарт ур чадварын нэмэгдэлийг 15%-иар буюу 138.2 мянган төгрөг, 03 сарын 15-ний өдрийн А/09 тоот тушаалаар 1-р улиралын үр дүнгийн урамшуулалд 6994.3 мянган төгрөг, 03 сарын 15-ний өдрийн А/11 тоот тушаалаар багш Б.Чимэгмаад ур чадварын нэмэгдэлийг үндсэн цалингийн 25%-иар буюу 152.1 мянган төгрөг, аймгийн Засаг даргын 2018 оны 04 сарын 23-ний өдрийн А/233 тоот захирамжаар 1-р улиралын үр дүнгийн урамшуулалд 277.2 мянган төгрөг, эрхлэгчийн 2018 оны 05 сарын 21-ний өдрийн А/26 тоот тушаалаар ур чадварын нэмэгдэлийг багш Г.Баасанжаргал, багш Д.Оюун-Эрдэнэ, Б.Чанцалдулам нарт үндсэн цалингийн 20%-иар буюу 339.6 мнган төгрөг, 05 сарын 21-ний өдрийн А/27 тоот тушаалаар ур чадварын нэмэгдэлийг угаагч Ц.Цэцэгмаад 15%-иар буюу 55.6 мянган төгрөг тус тус бодож олгосон байна.

6.2. Үндсэн хөрөнгийн хөдлөл өөрчлөлт: 2018 он

№	Нэр	Мөнгөн дүн /төгрөгөөр/			
		Эхний үлдэгдэл	Орлого	Зарлага	Эцсийн үлдэгдэл
1	Барилга байгууламж	325528975			325528975
2	Тавилга, эд хогшил	38712659			38712659
3	Машин тоног төхөөрөмж	24346133			24346133
4	Түүх соёлын дурсгалт зүйл	1340263493			1340263493
5	Програм хангамж	930000	300000		1230000
6	Бусад үндсэн хөрөнгө	28748788			28748788
7	Бусад биет бус хөрөнгө		35170000		35170000
	Дүн	1758530048	35470000	0	1794000048

2018 оны эхэнд мянган төгрөгийн үндсэн хөрөнгө дээр төсвийн хөрөнгөөр 78440.1 мянган төгрөгийн хөрөнгө авснаас барилга байгууламж дахин үнэлгээнд орж 71266.2 мянган төгрөгөөр нэмэгдэж 1199.9 мянган төгрөгийн компьютер, 5974.0 төгрөгийн биет бус хөрөнгө авсан байна. Оны эцэст 218402.0 мянган төгрөгийн үндсэн хөрөнгө бүртгүүлсэн байна.

6.3. Бараа материалын хөдлөл өөрчлөлт: 2018 он

№	Тайлангийн нэр	Мөнгөн дүн /төгрөгөөр/			
		Эхний үлдэгдэл	Орлого	Зарлага	Эцсийн үлдэгдэл
1	Эм боох материал	0	150000	150000	0
2	Хүнсний материал	6151120	57166370	57389011	5928479
3	Бичиг хэрэг	20000	2827050	2520920	326130
4	Аж ахуйн материал	4516412	4238990	1584600	7170802
5	Сэлбэг хэрэгсэл	153000	369900		522900
6	Түлш тослох материал	180000	235296	235296	180000
7	Барилгын материалын засвар	12000	11586660	9925220	1673440
8	Бусад хангамжийн материал	5872077	1486600	1486600	7358677
	НИЙТ ДҮН	41917383.70	83409616	72428904.20	52898095.50

2018 оны эхэнд 31118.9 мянган төгрөгний бараа материал дээр төсвийн хөрөнгөөр 23507.5 мянган төгрөгний бараа материал худалдан авч 17198.7 мянган

төгрөгний зарлага гарч оны эцэст 37427.8 мянган төгрөгний бараа материал бүртгэгдсэн байна.

6.4. Өглөг, авлагын талаар: 2018 онд ХХОАТ-ын өглөг 5226 төгрөг, ажиллагчидтай холбоотой авлага 125.5 мянган төгрөг.

6.5 Шилэн дансны талаар: Шилэн дансны тухай хуулийн дагуу шилэн дансны нэгдсэн системд 2018 төсөв гүйцэтгэлийн 49 мэдээлэл оруулхаас 1 мэдээлэл хоцроож, 48 мэдээлэлийг хугацаанд нь оруулсан. Хөрөнгө оруулалт, тендер худалтан авалтын 39 мэдээлэл оруулхаас 39 мэдээлэлийг хугацаанд нь оруулсан байна.

ДОЛОО. ШАЛГАЛТААР ИЛЭРСЭН ЗӨРЧИЛ, ТҮҮНИЙ ШАЛТГААН, ЗӨРЧИГДСӨН ХУУЛЬ, ТОГТООМЖ

Булган сумын 2-р цэцэрлэгийн 2017-2018 оны санхүүгийн баримтанд төлөвлөгөөт хяналт шалгалтыг 2019 оны 05 сарын 31-ний өдрөөс хоногийн хугацаан явууллаа.

НАЙМ. АВСАН АРГА ХЭМЖЭЭ, МЭРГЭЖЛИЙН ТУСЛАЛЦАА, ЗӨВЛӨГӨӨ ӨГСӨН БАЙДАЛ

Шалгалтын хугацаанд 2 албан тушаалтанд мэргэжил арга зүйн зөвлөгөө өгөв. Няравын агуулахын бүртгэлд байгаа хүнсний материалыг агуулахад байгаа хүнстэй түүвэрчилсэн байдлаар тулган шалгахад агуулахад байгаа материал агуулахын бүртгэлтэй зөрсөн энэ нь нярав агуулахын бүртгэлийг цаг тухайд нь хөтлөөгүй анхан шатны баримтыг дутуу хөтөлсөн байна.

ЕС. ДҮГНЭЛТ

Монгол улсын Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13.1, 13.5, 13.7 дахь /шинэчилсэн/ заалтууд, няравын тайлан гаргалт анхан шатны баримтын бүрдэлт сайн.

Ололт дэвшилттэй тал: Багш нарын мэргэжлийн ур чадвар, туршлагыг нэмэгдүүлэх, тэдний ажлын үр дүнг дэмжих, хүүхдийн сурах идэвхийг өрнүүлэх, сургалтын үйл ажиллагааг сайжруулах, сургалтын бэлтгэл үйл ажиллагааг дээшлүүлэх зорилгоор өдөр бүрийн сургалтын хөтөлбөрийг боловсруулж мэдээллийн цагийн сургалтын цагтай болсон байна.

Багш ажилчид өөрсдийн санал санаачилга, хүч, нөөц бололцоонд тулгуурлан цэцэрлэгийн гадна орчинг тохижуулан сайжруулж хүүхдүүдийн тоглох дуртай сонирхол татахуйцаар эрүүл аюулгүй тоглоомуудыг хийж бүтээн байгуулалт хийж ажилласан байна.

АРВАН НЭГЭН. ЦААШИД АНХААРАХ АСУУДАЛ

Тушаал шийдвэрийн үндэслэлийг хууль эрх зүйн дагуу үг үсгийн алдаагүй гаргах.

Монгол улсын нягтлан бодох бүртгэлийн тухай, төсвийн тухай хуулийг үйл ажиллагаандаа хэрэгжүүлж ажиллах

Санхүүгийн үйл ажиллагаандаа дотоодын хяналт шалгалтыг тогтмол хийж санхүүгийн сахилга хариуцлагыг дээшлүүлэх

БИЧСЭН: АУДИТОР

П.ПҮРЭВЖАВ